



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дэлгэрэх сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/26/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд

2021 он

Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 7052-2734

Цахим хаяг: Gan-Ulzii.t@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 7052-3020

Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор:

Ч.Ариунаа

Утас: 7052-3020

Цахим хаяг: Ariunaa.ch@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ТГТ	Төсвийн Гүйцэтгэлийн Тайлан
ОНТ	Орон Нутгийн Төсөв
ОАТ	Орлогын Албан Татвар
ҮДТ	Үр Дүнгийн Тайлан
НББ	Нягтлан Бодох Бүртгэл
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ХАБ	Хөдөлмөрийн Аюулгүй Байдал
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
БМ	Бараа Материал
СБТ	Санхүүгийн Байдлын Тайлан

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1.Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2.Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3.Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4.Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5.Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6.Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан	14
3.1.Ерөнхий зүйл	12
3.2.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3.Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	15
3.4.Материаллаг байдал	15
3.5.Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7.Шилэн дансны мэдээлэл	17
3.8.Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9.Аудитын илрүүлэлт	18
Залруулсан алдаа	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж	18
3.10.Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4.Менежментийн захидал	19
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

1 Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn	ДЭЛГЭРЭХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА П.ПҮРЭВСҮРЭН ТАНАА
2021. 02. 24 № 1-6/22	
танай _____ -ны № _____ -т	
Зөрчилгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын дарга 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Бусад мэдээлэл	
<p>Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.</p> <p>Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.</p>	
Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p> <p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.</p>	

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Т.ГАН-ӨЛЗИЙ

Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	54,353,378.62	60,978,686.62
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
33	АВЛАГА	374,996.00	1,133,356.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	374,996.00	440,718.00
335	Бусад авлага	-	692,638.00
3351	Байгууллагаас авах авлага	-	692,638.00
34	УРЬДЧИЛГАА	-	170,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	170,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	-	170,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	53,978,382.62	59,675,330.62
354	Хангамжийн материал	52,638,382.62	58,405,330.62
35410	Бичиг хэргийн материал	1,363,000.00	1,803,200.00
35420	Аж ахуйн материал	49,045,782.62	53,179,530.62
35430	Сэлбэг хэрэгсэл	1,755,600.00	1,755,600.00
35440	Түлш, шатах тослох материал	474,000.00	1,667,000.00
35600	Мал амьтад	1,340,000.00	1,270,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	834,991,794.96	1,309,801,268.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	834,991,794.96	1,309,801,268.16
392	Биет хөрөнгө	789,216,794.96	1,262,653,101.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	342,274,573.00	482,074,573.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(12,643,908.90)	(26,434,607.82)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	224,191,300.00	254,554,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(189,404,338.40)	(162,809,133.15)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	153,448,170.38	195,584,421.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	(137,830,532.80)	(148,233,699.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,383,659.00	30,567,959.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,406,616.72)	(25,439,718.32)
39214	Бусад үндсэн хөрөнгө	968,452,272.13	1,279,033,395.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	(562,247,782.73)	(616,244,887.59)
393	Биет бус хөрөнгө	45,775,000.00	47,148,166.72
39301	Програм хангамж	1,269,000.00	2,996,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(972,000.00)	(1,325,833.28)
39303	Бусад биет бус хөрөнгө	45,478,000.00	45,478,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	889,345,173.58	1,370,779,954.78
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,759,523.00	7,604,593.61
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,759,523.00	7,604,593.61
413	Өглөг	3,759,523.00	7,604,593.61
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,638,890.00	4,371,960.61
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	65,673.00	65,673.00
4136	Бусад өглөг	54,960.00	3,166,960.00
41361	Байгууллагад төлөх өглөг	47,300.00	369,300.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	7,660.00	2,797,660.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	885,585,650.58	1,363,175,361.17
51	Засгийн газрын хувь оролцоо	885,585,650.58	1,363,175,361.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	432,758,942.42	432,758,942.42
512	Хуримтлагдсан үр дүн	288,424,772.34	766,014,482.93
51210	Өмнөх үеийн үр дүн	288,424,772.34	288,424,772.34

Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51220	Тайлант үеийн үр дүн	-	477,589,710.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	164,401,935.82	164,401,935.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	889,345,173.58	1,370,779,954.78

2.2 АУДИТ ХИЙСЭН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	409,870,659.00	970,136,671.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	103,742,382.00	618,970,887.00
120	Нийтлэг татварын бус орлого	103,742,382.00	618,970,887.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	103,742,382.00	618,970,887.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	250,000.00	250,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	103,492,382.00	614,208,143.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ		4,512,744.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	306,128,277.00	351,165,784.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,030,677.00	24,927,584.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,030,677.00	24,927,584.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	283,097,600.00	326,238,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	283,097,600.00	326,238,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	421,050,176.73	476,802,713.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	420,765,176.73	476,802,713.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	417,257,297.73	472,402,743.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,252,086.00	222,720,763.33
210101	Үндсэн цалин	193,252,086.00	222,720,763.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,735,255.00	27,937,188.97
210201	Тэтгэврийн даатгал	16,450,737.00	19,355,211.63
210202	Тэтгэмжийн даатгал	1,423,892.00	1,913,430.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,770,836.00	1,987,273.80
210204	Ажилгүйдлийн даатгал	371,859.00	425,570.30
210205	Эрүүл мэндийн даатгал	3,717,931.00	4,255,703.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,504,341.00	20,819,779.00
210301	Гэрэл, цахилгаан	2,469,341.00	2,963,991.00
210302	Түлш, халаалт	4,814,000.00	17,855,788.00
210303	Цэвэр бохир ус	221,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	20,350,327.00	31,250,301.00
210401	Бичиг хэрэг	3,352,600.00	4,282,360.00
210402	Тээвэр, шатахуун	12,170,377.00	18,878,472.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,151,750.00	3,863,233.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	36,000.00	1,674,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,639,600.00	1,684,740.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	866,996.00
2105	Нормативт зардал	107,000.00	210,130.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	107,000.00	210,130.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	969,000.00	1,439,000.00
210604	Урсгал засвар	969,600.00	1,439,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,186,700.00	3,491,440.00
210702	Дотоод албан томилолт	8,186,700.00	3,491,440.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,539,874.00	28,493,019.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,877,200.00	27,706,019.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	120,000.00

Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	329,930.00	330,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,000.00	75,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	106,000.00	82,000.00
210807	Газрын төлбөр	175,744.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	137,612,114.73	136,041,122.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,876,800.00	6,660,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	167,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	133,735,314.73	129,213,422.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,507,879.00	4,399,969.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,210,000.00	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,210,000.00	400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,297,879.00	3,999,969.31
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,297,879.00	3,999,969.31
223001	Бусад хөрөнгө	285,000.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(11,179,517.73)	493,333,957.90
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	15,744,247.31
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	160,000.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал		15,584,247.31
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(15,744,247.31)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(11,179,517.73)	477,589,710.59

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	304,529,877.00	351,415,784.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	250,000.00	250,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	250,000.00	250,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	250,000.00	250,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	250,000.00	250,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	304,279,877.00	351,165,784.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,182,277.00	24,927,584.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,182,277.00	24,927,584.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	283,097,600.00	326,238,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	283,097,600.00	326,238,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	287,483,217.00	346,016,784.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	287,483,217.00	346,016,784.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	283,975,338.00	341,216,814.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	190,069,729.00	220,431,014.69
210101	Үндсэн цалин	189,819,729.00	220,431,014.69
210104	Урамшуулал	250,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,761,700.00	27,498,354.00
210201	Тэтгэврийн даатгал	15,953,900.00	18,530,552.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,877,000.00	2,507,153.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,501,600.00	1,700,730.00
210204	Ажилгүйдлийн даатгал	375,400.00	452,399.00

Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	4,053,800.00	4,307,520.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,347,608.00	20,311,779.00
210301	Гэрэл, цахилгаан	1,849,304.00	3,371,779.00
210302	Түлш, халаалт	6,248,304.00	16,940,000.00
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	20,186,627.00	28,320,765.00
210401	Бичиг хэрэг	2,399,200.00	3,510,493.00
210402	Тээвэр, шатахуун	13,317,977.00	19,759,832.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,525,450.00	4,107,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800,000.00	799,340.00
2105	Нормативт зардал	198,300.00	200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	198,300.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,479,300.00	1,475,350.00
210604	Урсгал засвар	1,479,300.00	1,475,350.00
2107	Томилолт, зочны зардал	8,186,700.00	2,785,300.00
210702	Дотоод албан томилолт	8,186,700.00	2,785,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,614,674.00	33,694,252.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,952,000.00	32,907,252.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	120,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	329,930.00	330,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,000.00	71,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	86,000.00	86,000.00
210807	Газрын төлбөр	175,744.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,130,700.00	6,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,130,700.00	1,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,507,879.00	4,799,969.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,210,000.00	800,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,410,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,297,879.00	3,999,969.31
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	963,079.00	3,999,969.31
213404	Төвлөрүүлэх шилжүүлэг	334,800.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17,046,660.00	5,399,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,046,660.00	5,399,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,046,660.00	5,399,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,046,660.00	5,399,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	399,000.00
223001	Бусад хөрөнгө	17,046,660.00	5,000,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.4 АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	432,758,942.42	164,401,935.82	288,424,772.34	885,585,650.58
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	432,758,942.42	164,401,935.82	288,424,772.34	885,585,650.58
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	432,758,942.42	164,401,935.82	288,424,772.34	885,585,650.58
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	432,758,942.42	164,401,935.82	288,424,772.34	885,585,650.58
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	432,758,942.42	164,401,935.82	288,424,772.34	885,585,650.58
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	477,589,710.59	477,589,710.59
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	432,758,942.42	164,401,935.82	766,014,482.93	1,363,175,361.17

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	326,488,200.00	322,488,230.69	3,999,969.31	98.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	326,488,200.00	322,488,230.69	3,999,969.31	98.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325,688,200.00	321,688,230.69	3,999,969.31	98.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,973,700.00	220,431,014.69	2,542,685.31	98.86
210101	Үндсэн цалин	222,973,700.00	220,431,014.69	2,542,685.31	98.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,871,700.00	27,498,354.00	373,346.00	98.66
210201	Тэтгэврийн даатгал	18,952,700.00	18,530,552.00	422,148.00	97.77
210202	Тэтгэмжийн даатгал	2,229,800.00	2,507,153.00	(277,353.00)	112.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,783,800.00	1,700,730.00	83,070.00	95.34
210204	Ажилгүйдлийн даатгал	446,000.00	452,399.00	(6,399.00)	101.43
210205	Эрүүл мэндийн даатгал	4,459,400.00	4,307,520.00	151,880.00	96.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,370,000.00	20,311,779.00	58,221.00	99.71
210301	Гэрэл, цахилгаан	1,849,700.00	3,371,779.00	(1,522,079.00)	182.29
210302	Түлш, халаалт	18,139,800.00	16,940,000.00	1,199,800.00	93.39

Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210303	Цэвэр, бохир ус	380,500.00	-	380,500.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	23,905,900.00	23,899,933.00	5,967.00	99.98
210401	Бичиг хэрэг	3,450,800.00	3,445,493.00	5,307.00	99.85
210402	Тээвэр, шатахуун	15,851,100.00	15,851,100.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,660,000.00	3,660,000.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	144,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800,000.00	799,340.00	660.00	99.92
2105	Нормативт зардал	200,000.00	200,000.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	200,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,480,000.00	6,475,350.00	4,650.00	99.93
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
210602	Тавилга	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	1,480,000.00	1,475,350.00	4,650.00	99.69
2107	Томилолт, зочны зардал	3,237,900.00	2,235,300.00	1,002,600.00	69.04
210702	Дотоод албан томилолт	3,237,900.00	2,235,300.00	1,002,600.00	69.04
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,749,000.00	13,737,500.00	11,500.00	99.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,962,000.00	12,950,500.00	11,500.00	99.91
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	120,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	330,000.00	330,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,000.00	71,000.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	86,000.00	86,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	180,000.00	180,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,900,000.00	6,899,000.00	1,000.00	99.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,900,000.00	1,899,000.00	1,000.00	99.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800,000.00	800,000.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	326,488,200.00	326,488,200.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	326,238,200.00	326,238,200.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	326,238,200.00	326,238,200.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	250,000.00	250,000.00	-	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	250,000.00	250,000.00	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	7.00	7.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100.00

Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0	24,927,584	(24,927,584)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0	24,927,584	(24,927,584)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0	24,927,584	(24,927,584)
2104	Хангамж, бараа материалын зардал	0	4,420,832	(4,420,832)
210401	Бичиг хэрэг	0	65,000	(65,000)
210402	Тээвэр, шатахуун	0	3,908,732	(3,908,732)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	447,100	(447,100)
2107	Томилолт, зочны зардал	0	550,000	(550,000)
210702	Дотоод албан томилолт	0	550,000	(550,000)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	19,956,752	(19,956,752)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	19,956,752	(19,956,752)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0	24,927,584	(24,927,584)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	24,927,584	(24,927,584)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	24,927,584	(24,927,584)

3 Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дэлгэрэх сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг П.Пүрэвсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үйлчлүүлэгчийн орлого, зардлын данс, батлагдсан төсөв гүйцэтгэлтэй холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021.01.28-аас 2021.02.02-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Ч.Ариунаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дэлгэрэх сумын ЗДТГ 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2021.01.25-ны өдрийн 01/35 дугаар бүхий албан бичгээр 2021.01.29-ний өдөр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ:

“Сум багийн ажлыг уялдуулан оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар аймгийн хөгжилд дэмжлэг үзүүлж, улмаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэж төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэхэд чиглэгдэнэ”

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

Дэлгэрэх сумын ЗДТГ нь ” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ: Төрийн болон төрийн бус байгууллага , аж ахуйн нэгж байгууллага , иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дэлгэрэх сумын ЗДТГ санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийгдээгүй байна.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны ТГТ-ын тайлангийн батлагдсан төсвийн дүн 323,718.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,237.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчиллөө.

Аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны нийт орлого 351,415.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 3,514.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дэлгэрэх сумын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 481,434.8 мянган төгрөгөөр буюу 54.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	374.9	1,133.3	758.4
Урьдчилгаа		170.0	170.0
Бараа материал	53,978.4	59,675.3	5,696.9
Үндсэн хөрөнгө	834,991.8	1,309,801.3	474,809.5
Нийт хөрөнгө	889,345.2	1,370,779.9	481,434.8
Өр төлбөр	3,759.5	7,604.6	3,845.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	885,585.6	1,363,175.4	477,589.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	889,345.2	1,370,779.9	481,434.8

Авлага дансны үлдэгдэл 1,133.3 мянган төгрөг болж 758.4 мянган төгрөгөөр өссөн нь ажиллагсадтай холбогдсон авлага өссөн нь шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 59,675.3 мянган төгрөг болж 5,696.9 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг, аж ахуйн материал, түлш, шатах тослох материалын үлдэгдэл нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,309,801.3 мянган төгрөг болж 474,809.5 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн дансанд ОНТ-ийн хөрөнгө оруулалтаар 614,208.1

мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 5,399.0 мянган төгрөг тус тус нэмэгдэж, 92,814.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 7,604.6 мянган төгрөг болж 3,845.0 мянган төгрөгөөр өссөн нь цалингаас суутгасан зарим суутгалыг шилжүүлээгүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,363,175.4 мянган төгрөг болж 477,589.8 төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Дэлгэрэх сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 560,266.0 мянган төгрөгөөр буюу 136.6 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 55,752.5 мянган төгрөгөөр буюу 0.13 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, эд хогшил, урсгал засварын зардлууд байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 423,638.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 423,638.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 97150.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 326,488.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 326,488.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 326,238.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 250.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 326,238.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 250.0 мянган төгрөг, нийт 326,488.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 322,488.3 мянган төгрөгийг зарцуулж 3,999.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 322,488.3 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь урсгал зардлыг 3,999.9 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 24,927.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж 100 хувь зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, 22 мэдээллийг хугацаа хоцроож, 125 мэдээллийг хугацаанд нь оруулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,850.1 мянган төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт, 9,122.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Аудитаар 2 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	5	3,850.1	1	1,656.0	4	2,194.1	
Албан шаардлага	1	9,122.8	-	-	1	9,122.8	
Зөвлөмж	2	-	2	-	-		
Нийт дүн	8	12,972.9	3	1,6156.0	5	11,316.9	

Төлбөрийн акт, албан шаардлагыг тогтоосон хугацаанд барагдуулаагүй албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15,327.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11,859.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 330.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 674.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 2,462.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Цалингийн тооцоо үүсгээгүй, ажил гүйлгээг мөнгөн сууриар бүртгэснээс авлага 920.5 мянган төгрөгөөр илүү, өглөг 5368.2 мянган төгрөгөөр дутуу тусгасныг СБТ-нд залруулга хийсэн
2. Төлөвлөлтийн үе шатанд 2340. мянган төгрөгийн шатахууны үнэ, хувь хүнээс суутгасан ОАТ-ын 10 хувь 834.3 мянган төгрөгийг шууд зардалд бүртгэснийг бараа материалын тодруулга тайланд залруулж бүртгэсэн
3. Төлөвлөлтийн үе шатанд шуудан үйлчилгээний зардлыг цалингийн зардалд бүртгэснийг ҮДТ-д залруулсан

4. Түлш, шатах тослох материалын бүртгэлийг эд хариуцагчийн тайлантай тулгахад Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулсан 2340.0 мянган төгрөгийг эд хариуцагчийн тайланд тусгаагүй байсныг БМ-ын тодруулга тайланд тусгасан

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

1. Засаг даргын орлогчид томилолтын хуудасгүй томилолт олгосон нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг зөрчиж, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Тайлант онд 8550.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгож, төрийн сангийн мэргэжилтнээс 170.0 мянган төгрөгийг суутгаагүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.3, 4.4.1 дэх заалтыг зөрчиж, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3. НДШ-ийн зардлаас 674.7 мянган төгрөгийн цалин хөлс олгосон нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4. Өмнөх онд 3,850.1 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоосон бөгөөд хэрэгжилт 43.0 хувьтай байна. Төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулаагүй 2,194.1 мянган төгрөгийн зөрчил байна. Мөн 9,122.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн бөгөөд хариу ирүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 2,462.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 Зардлын данстай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт:

ЗД-ын орлогчид ХАБ-ын нэмэгдэлд үндсэн цалингаас тооцож 15 хувийн нэмэгдэл олгосон бөгөөд аудитын явцад ажлын гүйцэтгэл, тайланг ирүүлээгүй байна.

4.1.2 Эрсдэл

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь заалт тус тус зөрчсөн байна.

4.1.3 Зөвлөмж

Хавсран ажиллаж буй албан тушаалын ажил үүргийг тодорхой болгож, ажлын гүйцэтгэл, тайланд үндэслэн цалин хөлс, нэмэгдлийг олгож байх

4.2 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт

Тэтгэмж урамшууллын зардал хүрэлцэхгүйгээс цалингийн зардлаас 2 албан хаагчид 1,010.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон байна.

4.2.2 Эрсдэл

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг зөрчсөн байна.

4.2.3 Зөвлөмж

Төсвийг бодитой төлөвлөж батлуулах, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж байх

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

4.3.1 Илрүүлэлт

Бичиг хэргийн материалын данснаас 4 ширхэг флашыг шаардах хуудсаар данс бүртгэлээс хассан

4.3.2 Эрсдэл

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна АИТХ-ын 2019 оны 70 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар зүйлийн 3.3.2 дахь заалт тус тус зөрчсөн байна.

4.3.3 Зөвлөмж

Цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгө, бараа материалыг данс бүртгэлээс хасахдаа тооллогын комисс, өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн шийдвэрлэх.

4.4 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

4.4.1 Илрүүлэлт

2020 оны 10 дугаар сард төсөвт тодотгол хийж тээвэр шатахууны зардлыг 5.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 15.8 сая төгрөг болгон баталсан. Үлдэгдэл өмнөх оноос өссөн, шатахууны талон нөөцөлсөн байна.

4.4.2 Эрсдэл

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт тус тус зөрчсөн байна.

4.4.3 Зөвлөмж

Төсвийг бодитой төлөвлөж хэмнэлттэй зарцуулах, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсөвт буцаан төвлөрүүлэх

4.5 Орлогын данстай холбоотой асуудал

4.5.1 Илрүүлэлт

Нэмэлт санхүүжилтийн данснаас 1350.0 мянган төгрөгийн оготно устгах утагч багаж авсан бөгөөд данс бүртгэлд тусгаагүй байна

4.5.2 Эрсдэл

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалт тус тус зөрчсөн байна.

4.5.3

Утагч багажийг данс бүртгэлд тусгаж, хариу ирүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дэлгэрэх сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ДГА-2021/26/СТА- ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дэлгэрэх сумын ЗДТГ		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	2020 оны 10 дугаар сард төсөвт тодотгол хийж тээвэр шатахууны зардлыг 5.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 15.8 сая төгрөг болгон баталсан. Үлдэгдэл өмнөх оноос өссөн, шатахууны талон нөөцөлсөн байна.	-	Зөвлөмж өгөх	ЗДТГ-ын дарга	П.Пүрэвсүрэн
2	НДШ-ийн зардлаас 674.7 мянган төгрөгийн цалин хөлс олгосон	674.7	Албан шаардлага өгөх	ЗДТГ-ын дарга	П.Пүрэвсүрэн
3	ЗД-ын орлогчид ХАБ-ын нэмэгдэлд үндсэн цалингаас тооцож 15 хувийн нэмэгдэл 1468.5 мянган төгрөг олгосон	-	Зөвлөмж өгөх	ЗДТГ-ын дарга	П.Пүрэвсүрэн
4	Бичиг хэргийн материалын данснаас 4 ширхэг флашыг шаардах хуудсаар данс бүртгэлээс хассан	102.9	Зөвлөмж өгөх	ЗДТГ-ын дарга	П.Пүрэвсүрэн
5	Засаг даргын орлогчид томилолтын хуудасгүй томилолт олгосон	160.0	Төлбөрийн акт тогтоох	ЗДТГ-ын дарга	П.Пүрэвсүрэн
6	Төрийн сангийн мэргэжилтнээс 170.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа суутгаагүй байна	170.0	Төлбөрийн акт тогтоох	ЗДТГ-ын дарга	П.Пүрэвсүрэн
7	Цалингийн зардлаас буцалтгүй тусламж олгосон байна.	1010.0	Зөвлөмж өгөх	ЗДТГ-ын дарга	П.Пүрэвсүрэн
8	Оготно устгагч багажийг данс бүртгэлд тусгаагүй байна	1350.0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Э.Баттогоо
9	Өмнөх онд 3,850.1 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоосон бөгөөд хэрэгжилт 43.0 хувьтай байна. Төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулаагүй 2,194.1 мянган төгрөгийн зөрчил байна. Мөн 9,122.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн бөгөөд хариу ирүүлээгүй байна.	11,316.9	Хариуцлага тооцуулах		
10	В30103 маягтаар СБТ, ҮДТ, БМ-ын тодруулга тайланд залруулга хийсэн	11,859.4	Залруулга хийсэн	Нягтлан бодогч	Э.Баттогоо
ДҮН		26,643,9			